

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	8
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	8
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	9
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ
ДЭМЖИХ” ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Н.МОНГОЛМАА
ТАНАА

2020.03.06 № 06/734
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу, үнэн бодит, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус төсөлд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн зохицуулагч Н.Монголмаа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төсөл нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төслийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Нийслэл аудит” ХХК-ийн аудитор Б.Өлзийзаяа, шинжээч Д.Энхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 09/20 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь ажил хайгч, бичил бизнес эрхлэгчид хөдөлмөрийн зах зээл дээр гарч ирж буй боломжуудаас хүртэхэд нь дэмжлэг үзүүлэх юм.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгох
- Хөдөлмөрийн зах зээлийн зарим хөтөлбөрийг боловсронгуй болгох
- Хөдөлмөрийн зах зээлийн хяналт, дүн шинжилгээг сайжруулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй бөгөөд хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны журам
- Дэлхийн банкны төсөл хэрэгжүүлэх заавар
- Дэлхийн банкны төслийн хөрөнгийн зарцуулалтын захидал

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төслийн Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа Дэлхийн банкнаас гаргасан төсөл хэрэгжүүлэх заавар нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Project finance хангамж ашигладаг байна.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 4 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 9,508,552.6 мянган төгрөгөөс тооцон 190,171.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 78,782.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,679,331.1	2,626,267.6	(53,063.5)
Үндсэн хөрөнгө	259,864.9	234,146.2	(25,718.8)
Нийт хөрөнгө	2,939,196.0	2,860,413.7	(78,782.3)
Өр төлбөр	-	4,829.8	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	-	2,855,583.9	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,939,196.0	2,860,413.7	(78,782.3)

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант хугацааны 27,408.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,829.8 мянган төгрөгөөр өссөн нь нэр данс зөрүүтэй буцаагдсан гүйлгээтэй холбоотой байна.

2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 15,000,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 870,741.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 524,066.6 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 8,000,000.0 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлд зарцуулахаар батлагджээ. Энэ зээл нь дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харъяа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар жижиг зээлийг хөдөө орон нуггийн иргэн, аж ахуй нэгжид арилжааны банкаар дамжуулан зээлдүүлдэг.

Нийт зардлыг Дэлхийн банкнаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээнд нийт 15,000,000.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 9,394,808.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл, горим сорил хэрэгжүүлжээ.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

2019 оны аудитаар үйл ажиллагааны орлого, зарлага, зөвлөх үйлчилгээний болон дамжуулан зээлдүүлж буй зээлийн зарцуулалтыг нарийвчлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төсөл Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 51 мэдээллийг хугацаанд нь, 49 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,679,331,085.04	2,626,267,546.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,679,331,085.04	2,626,267,546.90
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	507,273.00	
31211	Банкнид байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	1,821,138.59	24,386,815.54
31212	Банкнид байгаа бэлэн мөнгө /гадаад валютаар/	2,677,002,673.45	2,167,604,712.10
31213	Банкнид байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/ Төрийн сан үйл ажиллагаа	-	34,574,213.95
31214	Банкнид байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/ Төрийн сан	-	399,701,805.31
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	259,864,928.19	234,146,146.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	245,415,428.19	219,696,646.59
39201	Авто-тээврийн хэрэгсэл	131,727,272.73	131,727,272.73
39202	Хуримтлагдсан элэгдэл	(5,488,636.36)	(18,661,363.60)
39203	Машин, тоног төхөөрөмж	83,500,454.55	83,500,454.55
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,175,022.73)	(12,525,069.01)
39205	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,948,800.00	41,948,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,097,440.00)	(6,293,448.08)
39300	Биет бус хөрөнгө		
39301	Программ хангамж	15,210,000.00	16,900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(760,500.00)	(2,450,499.96)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,939,196,013.23	2,860,413,693.53
41	Богино хугацаат өр төлбөр	-	4,829,787.00
41300	Өглөг		
413010	Ажиллагчидтай холбогдсон өглөг		
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		4,829,787.00
41400	Урьдчилж орсон орлого		
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	4,829,787.00
51200	Хуримтлагдсан үр дүн		
51210	Өмнөх үеийн үр дүн	-	2,939,196,013.20
51220	Тайлант үеийн үр дүн	2,939,196,013.23	(83,612,106.80)
51300	Дахин үнэлгээний нэмэгдэл		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,939,196,013.23	2,855,583,906.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,939,196,013.23	2,860,413,693.53

3.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
	Төсөвт байгууллагын өөрийн орлого		
120001	Улсын төсвөөс	-	-
120003	Зээлийн хөрөнгөөр санхүүжсэн орлого	6,003,625,985.40	9,336,915,000.00
	Гадаад эх үүсвэрээс санхүүжих		
	Хүүгийн орлого	90,892,397.43	46,575,633.62
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,094,518,382.83	9,383,490,633.62
210200	Цалин	235,047,174.72	-
210201	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	32,333,501.39	-
210202	Эрүүл мэндийн даатгалын хураамж	10,210,579.39	-
2109	Бусад бараа үйлчилгээний зардал		
210901	Бичиг хэргийн материал	5,731,370.00	7,206,177.27
210902	Тээвэр, шатахууны зардал	14,280,326.00	10,981,572.00
210903	Шуудан холбооны зардал	1,769,605.04	4,054,480.26
210701	Гадаад томилолтын зардал		19,506,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардал	3,283,698,655.00	447,166,284.49
210802	Бусад зардал	-	360,667,694.33
210803	Байрны түрээсийн зардал	69,020,000.00	60,918,985.00
210804	Элэгдлийн зардал	12,521,599.09	27,408,781.56
210805	Төвлөрүүлэн шилжүүлэг	-	46,575,633.62
210806	Нөхцөлт зээл		8,000,000,000.00
210807	Их засвар		520,284,079.00
210808	Тоног төхөөрөмж		3,782,520.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3,664,612,810.63	9,508,552,607.53
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,429,935,572.23	(125,061,973.91)
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	509,260,441.03	57,878,201.36
14	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз(бодит)	509,260,441.03	57,878,201.36
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	509,260,441.03	57,878,201.36
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		(16,428,334.15)
225004	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз (бодит)		(16,428,334.15)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)		(16,428,334.15)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	2,939,196,013.23	(83,612,106.70)

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	6,094,518,382.83	9,388,320,420.62
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	6,094,518,382.83	9,388,320,420.62
1200041	Зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс олгосон санхүүжилтийн орлого	-	9,336,915,000.00
1200043	Гадаад эх үүсвэрээс	6,003,625,985.43	
1200045	Хүүний орлого	90,892,397.40	46,575,633.62
1200046	Бусад орлого (буцаагдсан гүйлгээ)		4,829,787.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,652,061,211.54	957,077,226.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,652,061,211.54	957,077,226.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,652,061,211.54	957,077,226.97
2101	Цалин хөдөлмөрийн хөлс	277,561,255.50	-
210101	Үндсэн цалин	235,017,174.76	-
210102	Тэтгэвэр, тэтгэмжийн шимтгэл	32,333,501.39	-
210103	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	10,210,579.39	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,020,000.00	60,918,985.00
210301	Байрны түрээс	69,020,000.00	60,918,985.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,781,301.00	382,909,923.86
210401	Бичиг хэргийн материал	5,731,370.00	7,206,177.27
210402	Тээвэр, шатахууны зардал	14,280,326.00	10,981,572.00
210403	Шуудан холбооны зардал	1,769,605.00	4,054,480.26
210404	Бусад зардал	-	360,667,694.33
2107	Гадаад томилолтын зардал	-	19,506,400.00
210701	Гадаад томилолтын зардал	-	19,506,400.00
	Төвлрүүлэх шилжүүлэг	-	46,575,633.62
	Төвлрүүлэх шилжүүлэг		46,575,633.62
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,283,698,655.00	447,166,284.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,283,698,655.00	447,166,284.49
2133	Хөрөнгийн зардал	-	524,066,599.00
213301	Их засвар		520,284,079.00
213302	Тоног төхөөрөмж		3,782,520.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	2,442,457,171.29	7,907,176,594.65
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	272,386,527.28	8,001,690,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	272,386,527.28	1,690,000.00
225107	Гадаад төслийн зээл		8,000,000,000.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	509,260,441.03	41,449,867.21
250001	Гадаад валютийн ханшийн зөрүүний олз	509,260,441.03	41,449,867.21
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,679,331,085.04	(53,063,538.14)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,679,331,085.04
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,679,331,085.04	2,626,267,546.90

3.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээн ий нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	2,939,196,013.23	2,939,196,013.23
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	2,939,196,013.23	2,939,196,013.20
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	2,939,196,013.23	2,939,196,013.20
Тайлант үеийн үр дүн	-	-	(83,612,106.70)	(83,612,106.70)
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	2,855,583,906.53	2,855,583,906.53

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,000,000,000.0	9,394,808,325.2	5,605,191,674.9	63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,400,000,000.0	870,741,726.2	3,529,258,273.9	20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,400,000,000.0	870,741,726.2	3,529,258,273.9	20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил			-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл			-	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,000,000.0	60,918,985.0	19,081,015.0	76
210301	Гэрэл, цахилгаан	-	-	-	
210304	Байрны түрээс	80,000,000.0	60,918,985.0	19,081,015.0	76
2104	Хангамж, бараа материалын зардал	42,000,000.0	22,242,229.6	19,757,770.4	53
210401	Бичиг хэрэг	12,000,000.0	7,206,177.3	4,793,822.7	60
210402	Тээвэр, шатахуун	24,000,000.0	10,981,572.0	13,018,428.0	46
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000,000.0	4,054,480.3	1,945,519.7	68
2105	Нормативт зардал	-	-	-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	-	
2107	Томилолт, зочны зардал	212,000,000.0	19,506,400.0	192,493,600.0	9
210703	Гадаад албан томилолт	212,000,000.0	19,506,400.0	192,493,600.0	9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,600,000,000.0	407,406,417.3	1,192,593,582.8	25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,600,000,000.0	407,406,417.3	1,192,593,582.8	25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,466,000,000.0	360,667,694.3	2,105,332,305.7	15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,466,000,000.0	360,667,694.3	2,105,332,305.7	15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	-	
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	-	
213207	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	-	-	
213208	Төвлөрүүлэн шилжүүлэг	-	-	-	
2133	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,600,000,000.0	524,066,599.0	2,075,933,401.0	20
213304	Хөрөнгийн зардал	2,600,000,000.0	524,066,599.0	2,075,933,401.0	20
2134	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	8,000,000,000.0	8,000,000,000.0		
213402	Гадаад төслийн зээл	8,000,000,000.0	8,000,000,000.0	-	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,000,000,000.0	9,341,744,787.0	5,658,255,213.0	62
1200045	Зээлийн санхүүжилтээс	15,000,000,000.0	9,336,915,000.0	5,663,085,000.0	62
1200047	Бусад /буцаагдсан гүйлгээ/	-	4,829,787.0	(4,829,787.0)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,679,331,085.1	2,679,331,085.1		100
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,626,267,546.9	(2,626,267,546.9)	

ТЭМДЭГЛЭЛ

A series of 25 horizontal dotted lines for writing.

